

**МУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2021 ОНЫ
СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ
ТЕЛЕВИЗИЙН МОНИТОРИНГ-НЭГДҮГЭЭР ҮЕ**

Мониторингийн хамрах хугацаа

5-р сарын 28-аас 6-р сарын 1

МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО

МУ-ын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийн үеэр ХМХ-ийн гүйцэтгэх үүргийг сайжруулах, иргэд, сонгогчдыг сонгуульд үнэн бодит мэдээлэлтэйгээр оролцоход нь хувь нэмэр оруулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулж буй сурталчилгааны тэгш, тэнцвэрт байдал хэрхэн хангагдаж буйг олон нийтэд ойлгуулах, далд сурталчилгааг илрүүлэх, Сонгуулийн тухай хууль болон ХХЗХ, СЕХ-ны хамтран баталсан “Радио телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих” журмын хэрэгжилтэд хяналт тавих явдал юм.

ЗОРИЛТ

СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ:

41.6, 41.7, 41.12, 41.13, 41.14, 41.16, 41.17, 41.27, 41.28

СЕХ, ХХЗХ-ны хамтран баталсан журам:

2.12.2, 2.12.3, 3.1, 3.2.3, 3.4, 3.5, 3.8, 3.8.13.8.3, 3.10, 3.13, 3.14.1-3.14.4,
3.15, 3.16

ТЭГШ ХАНДАХ

СТХ: 41.2, 41.6, 41.7, 41.12, 41.13, 41.14, 41.16

- Цаг хуваарилалт
- Мэдээллийн өнгө аяс

СОНГУУЛИЙН ХАРААТ БУС СЭТГҮҮЛ ЗҮЙН НЭВТРҮҮЛГИЙН ЦАГ, ЧАНАРЫГ ТОДОРХОЙЛОХ

СТХ: 41.13, 41.14, 41.15, 41.17

- Мэдээний хөтөлбөр
- Сонгогчдын боловсролд зориулсан мэдээллийн тусгай хөтөлбөр

ДАЛД СУРТАЛЧИЛГАА

Хуулийн хязгаарлалт

- 41.6. Олон нийтийн радио телевизээс бусад радио телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт /60 минут/-аас илүүгүй байна.
- 41.7. Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хоногт гарах нийт хугацаа /60 минут/-ны хорин таваас илүүгүй хувь /15 минут/ нь нэг нам, эвслээс нэр дэвшигчид ноогдоно.
- 41.14. Радио телевизийн мэдээний хөтөлбөрөөр нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар гарсан мэдээ нь сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хугацаанд хамаарахгүй боловч нэг нам эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээг хоногт таван минутаас хэтрүүлэхийг хориглоно.
- 41.28. Радио, телевизийн мэдээллийн хөтөлбөр, сургалтын болон хүүхдэд зориулсан нэвтрүүлэг дундуур сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.

Хуулийн хязгаарлалт

3.8. Энэ журмын 3.1-т заасныг хангаагүй, сонгуулийн сурталчилгаа гэдгээ тодорхой илэрхийлээгүй, захиалагч, нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг дурдаагүй сонгуулийн сурталчилгааны болон сонгуулийн сурталчилгааны бус дараах нэвтрүүлэг гаргасан бол сонгуулийн сурталчилгааны хугацаанд хамааруулж тооцно. Үүнд:

3.8.1. нам, эвсэл, нэр дэвшигчид хамаарах, захиалагч, нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг дурдаагүй төлбөрт, захиалгат нэвтрүүлэг, зар сурталчилгаа нэвтрүүлсэн бол;

3.8.2. захиалагч, нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг тодорхой дурдаагүй аливаа нэвтрүүлэгт улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн таних тэмдэг, уриа, намын далбаа, зураг, дүрс, нэрийг үзэгч, сонгогчдод сонгуулийн сурталчилгаа гэж ойлгогдохуйц байдлаар харуулах, дурдах, байршуулах, дууны үгэнд дурдсан бол;

3.8.3. сонгуулийн сурталчилгааны бус нэвтрүүлэг, арилжааны сурталчилгаа зэрэгт нам, эвсэл, нэр дэвшигчийн таних тэмдэг, уриа, намын далбаа, зураг, дүрс бичлэг, яриа нь орсон бол.

МОНИТОРИНГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Мониторингд хамрагдах телевизүүдийг дараах шалгуурыг үндэслэн сонгов.

- ✓ Олон нийтийн буюу төсвийн санхүүжилт ашигладаг
- ✓ Хамгийн хүртээмжтэй, орон даяар цацагддаг
- ✓ Үзэгчдийн тоо, рейтинг өндөр
- ✓ Зах зээлд удаан хугацаагаар оршин тогтнож, үйл ажиллагаа явуулж буй
- ✓ Зөвхөн агаарын долгион ашигладаг.









Өглөөний 07 цагаас шөнийн 02 цаг хүртэлх эфирт үзлэг хийсэн.

МОНИТОРИНГИЙН ХАМРАХ ХУГАЦАА

Ням	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба
						1
2	3	4	5	6	7	8
9	10	11	12	13	14	15
16	17	18	19	20	21	22
23	24	25	26	27	28	29
30	31	1				

Сонгуультай холбоотой мэдээлэлд зарцуулсан цаг


2021 оны 5 сарын 28-аас 6-р сарын 1

							НИЙТ
Нийт эфирийн цаг	93:28:50	98:25:00	84:25:28	95:00:00	94:01:00	465:20:18	
Сонгуультай холбоотой мэдээлэл	(8%)	(7%)	(7%)	(5%)	(5%)	(6%)	


Сонгуулийн тухай мэдээллийн хэлбэрүүд

ТЕЛЕВИЗ	МҮОНТ	TV9	25 дугаар суваг	NTV	МОНГОЛ HD	Арилжааны ТВ
Захиалгат нэвтрүүлэг	(50%)	(38%)	(44%)	(54%)	(51%)	47%
Далд сурталчилгаа	(20%)	(19%)	(20%)	(13%)	(10%)	15%
Сонгогчдын боловсролд	(30%)	(43%)	(37%)	(34%)	(38%)	38%


Захиалгат нэвтрүүлэг




Далд сурталчилгаа



Сонгогчдын боловсрол



5 ТЕЛЕВИЗИЙН НИЙТ МЭДЭЭЛЛИЙН ӨНГӨ АЯС



Мэдээний хөтөлбөрөөр гарсан СХМ


ТЕЛЕВИЗ



Хугацаа


02:05:59 (29%)	01:15:09 (19%)	02:15:56 (41%)	00:47:32 (18%)	01:16:17 (27%)	27%
-------------------	-------------------	-------------------	-------------------	-------------------	-----

МЭДЭЭНИЙ ХӨТӨЛБӨРӨӨР ГАРСАН СОНГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ




МҮОНТ-ийн нэр дэвшигчдэд оноосон цаг

МҮОНТ




МҮОНТ-МЭДЭЭЛЛИЙН ӨНГӨ АЯС




Мэдээний хөтөлбөрт эзлэх хувь /нэр дэвшигчээр/


МУОНТ




Арилжааны телевиз




АРИЛЖААНЫ ТЕЛЕВИЗ



Арилжааны телевиз- Мэдээллийн өнгө аяс /Нэр дэвшигчээр/



Далд сурталчилгаа / нэр дэвшигчээр/



Мэдээллийн агуулга

- Гэр бүл, найз нөхөд, өөрийн тухай-26%
- Мөрийн хөтөлбөр тайлбарласан 13%,
- Уриа үг хэлэх, зар сурталчилгаа явуулах 6%
- Ажлаа тайлагнасан-7%,
- Уул уурхай, хүнд үйлдвэр 3%
- Батлан хамгаалах яамны бодлогын хүрээний асуудал-4%
- Авлига, шударга ёс-1%
- Эдийн засаг 1%,
- Хууль эрх зүй-1%
- Боловсрол-1%
- Соёл урлаг-1%
- Хөдөө аж ахуй 1%
- Эрүүл мэнд-1%
- Гадаад харилцаа-1%
- Байгаль орчин, аялал жуулчлал
- Бусад-31%

Хуулийн хязгаарлалт

41.6, /60 минут/ - ЗӨРЧИЛГҮЙ

41.7, /15 минут/ - ЗӨРЧИЛГҮЙ

41.14 /5 минут/

ӨДӨР	ТЕЛЕВИЗ	НЭР ДЭВШИГЧ	ХЭТЭРСЭН ХУГАЦАА
5/31/2021	TV9	У.Хүрэлсүх	00:04:09
5/31/2021	25 дугаар суваг	У.Хүрэлсүх	00:00:37
6/1/2021	NTV	У.Хүрэлсүх	00:02:18

ДҮГНЭЛТ

МҮОНТ болон арилжааны телевизүүд нэр дэвшигч тус бүрт цаг хуваарилалтын хувьд адил тэгш хандаагүй. МАН-аас нэр дэвшигч У.Хүрэлсүхэд оноосон цаг дангаараа 47% эзэлсэн. Түүнчлэн арилжааны телевизүүдэд 51-ээс дээш хувь эзэлсэн.

Сонгуультай холбоотой мэдээллийн 64%-ийг захиалгатай төлбөртэй нэвтрүүлэг болон далд сурталчилгааны шинжийг агуулсан мэдээлэл эзлэв.

Сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл сурталчилгааны өмнөх үеэс 4 пунктээр буурсан сөрөг үзүүлэлтэй байна.

Далд сурталчилгааны шинжийг агуулсан мэдээлэл дунджаар 16% эзэлснийг гол төлөв цаг үеийн мэдээний хөтөлбөрөөр нэвтрүүлжээ. МАН-аас нэр дэвшигч У.Хүрэлсүхийн далд сурталчилгаанд эзлэх хувь 65%, АН-аас нэр дэвшигч С.Эрдэнэ 25%, ЗХЭЭ-ээс нэр дэвшигч Д.Энхбат 10% болов.

Хэт магтаж, сайшаасан мэдээлэл өсөж 93% хүрсэн бол төвийг сахисан өнгө аястай мэдээлэл ердөө 3% болов.

Сонгуультай холбоотой мэдээллийг агуулгын хувьд ангилан үзвэл гэр бүл болон өөрийн тухай нэвтрүүлсэн мэдээлэл өсөж 26% хүрсэн бол нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөртэй холбоотой мэдээллийн эзлэх хувь буурч 13% болов. Түүнчлэн уриа үг хэлэх, зар сурталчилгааны агуулга бүхий мэдээлэл буурч 6% хүрсэн боловч, ажлаа тайлагнасан мэдээллийн хэмжээ 3 пунктээр өссөн байна. Нигмийн бусад асуудлыг хөндсөн агуулга мөн л хомс байлаа.

Нэр дэвшигч өөрийн захиалгын цагтаа өөрийгөө сурталчлахын зэрэгцээ өрсөлдөгчөө сөргөөр мэдээлэх тохиолдол байсаар байна.

СТХ-ийн 60 минут, 15 минут зөрчсөн тохиолдол илрээгүй боловч 5 минутын хязгаарлалтыг зөрчсөн МАН-ын нэр дэвшигчтэй холбоотой 37 секундээс 4 минут 9 секунд хүртэлх 3 тохиолдол бүртгэгджээ.